

Монгол хувилбарыг дор хавсаргав

## **Монгол Улсын хууль зүйн тогтолцооны бие даасан байдалд үнэлгээ хийх НҮБ-ын шинжээчийн айлчлалын тухай**

Женев хот (2022 оны 11 дүгээр сарын 3) – Шүүгч, хуульчдын бие даасан, хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай төлөөлөгч Маргарет Саттервэйт 2022 оны 11 дүгээр сарын 6-наас 15-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийнэ.

Айлчлалын явцад хатагтай М. Саттервэйт шүүх засаглал, прокурорын бие даасан, шудрага байдал, тухайлбал хууль эрх зүйн мэргэжлийн үйл ажиллагааг хангахад төр засгийн зүгээс хэрэгжүүлсэн арга хэмжээнд үнэлгээ дүгнэлт хийх болно.

Тусгай төлөөлөгч шүүх засаглалын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хууль эрх зүйн ажиллагааны захиргаа, шүүх засаглалын ажилтнуудын хамгаалалт, шудрага шүүх, үүнтэй холбоотой жендерийн төлөв хандлага зэрэг асуудлуудад анхаарал хандуулна. Түүнчлэн хатагтай М.Саттервэйт шүүх, хууль эрх зүйн тусламж зөвлөлгөө авах тэгш эрх, монголын жирийн иргэд шүүхийн тогтолцоог хэрхэн хүлээн авдаг асуудлыг судална.

Шинжээч төр засгийн түшмэл, УИХ-ын гишүүд, шүүгч, прокурор, хуульчид, түүнчлэн иргэний нийгэм, эрдэмтэн судлаач, НҮБ-ын агентлагууд, хандивын болон дипломат байгууллагуудын төлөөлөлтэй уулзана.

Хатагтай М.Саттервэйт 11 дүгээр сарын 15-ны Лхагва гарагийн 11.30 цагт Улаанбаатар дахь НҮБ-ын байранд (UN House) хэвлэлийн бага хурал хийх бөгөөд түүнд зөвхөн сэтгүүлчдийг оролцуулна.

Тусгай төлөөлөгч айлчлалын тайлангаа Хүний Эрхийн Зөвлөлд 2024 оны 6 дугаар сард танилцуулна.

Шинжээчийн тухай: Хатагтай М.Саттервэйт, шүүгч, хуульчдын бие даасан, хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай төлөөлөгч. Тэрээр шүүгч, хуульчдын бие даасан, хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай төлөөлөгчөөр Хүний Эрхийн Зөвлөлийн шийдвэрээр 2022 оны 10 дугаар сард томилогдсон. Хатагтай М.Саттервэйт хүний эрхийн чиглэлээр олон арван жил мэргэшсэн олон улсын судлаач, шинжээч, Нью Йоркийн Их сургуулийн Хуулийн сургуулийн Хууль зүйн ухааны профессор болно.

*Шинжээчид нь Хүний Эрхийн Зөвлөлийн Тусгай процедур хэмээх үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл дахь бие даасан шинжээчдийг нэгтгэсэн хамгийн том байгууллага юм. Тусгай процедур нь тус зөвлөлийн*

мониторинг, бодит байдлын судалгаа, зарим тодорхой улс орны нөхцөл байдал болон дэлхий дахины өнцөг бүрийн сэдэвчилсэн асуудлаар бие даасан судалгааг хэрэгжүүлэх зорилготой. Тусгай процедурын шинжээчид НҮБ-ын ажилтнууд бус, хийсэн судалгааны цалин хөлс авдаггүй, сайн дурын үндсэн дээр ажилладаг, аливаа улс орны төр засаг, байгууллагаас хараат бус, зөвхөн хувийн эрмэлзэлд тулгуурлан үүргээ гүйцэтгэдэг болно.

НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, Улсын цахим хуудас – Монгол Улс

Дэлгэрэнгүй болон хэвлэлийн мэдээллийг [hrc-sr-independencejl@un.org](mailto:hrc-sr-independencejl@un.org) цахим хуудаснаас авна уу

НҮБ-ын бие даасан бусад шинжээчдийн мэдээллийг Maya Derouaz ([maya.derouaz@un.org](mailto:maya.derouaz@un.org)), Dharisha Indraguptha ([dharisha.indraguptha@un.org](mailto:dharisha.indraguptha@un.org)) нараас авна уу.

НҮБ-ын хүний эрхийн бие даасан шинжээч нартай холбоотой мэдээ мэдээллийг Twitter [@UN\\_SPExperts](https://twitter.com/UN_SPExperts) байршуулав.

Оршин амьдарч буй дэлхий дахины талаар санаа тавьж байгаа бол хэн нэгний эрхийн төлөө тэмцэлд нэгдэхийг уриалж байна.

#Standup4humanrights

<http://www.standup4humanrights.org>